БАТЛАВ
СУМЫН ЗАСАГ ДАРГА
А.МӨНХ-ОРГИЛ

2025.12.02 Цэнхэрмандал сум

Орон нутгийн чанартай 3.1 км замын засвар,
гэр хорооллын шороон замыг тэгшлэх, засварлах
ажлын техникийн тодорхойлолт

1.Төсөвт өртөг: 49144800

2. Байршил: Цэнхэрмандал сумын төв, Баянмод баг

3. Хэрэгжих хугацаа: 2026.05.15-2026.05.30

4. Гүйцэтгэх ажлын даалгавар:

Улсын чанартай авто зам,орон нутгийн чанартай авто замын уулзвараас сумын төв,засаг даргын тамгын газрын урд талын автомашины зогсоол хүртэлх 3.1 км авто замын нийт 108 хэсэг газрын 136 м2 талбайн эвдрэлийг асфальтаар нөхөх, гэр хорооллын шороон замыг 3 эгнээнд засварлах,тэгшлэх ажил багтана.

5. Техникийн шаардлага:

Орон нутгийн чанартай авто замын эвдрэлийг завсарлахдаа нийт 108 хэсэг газрын 136 м2 эвдэрсэн хэсгийг технологийн дагуу зориулалтын шаардлага хангасан асфальт ашиглан нөхөх ба тээврийн хэрэгсэл зорчиход хонхойж ус тогтохгүй,эвдрэлд орохгүй байхаар тооцож нөхөөс хийнэ.

Авто замын нөхөөсийг хийхдээ замын засвар арчлалтын ажлын технологийн дагуу эвдэрсэн хэсгүүдийг хөрөөдөж нөхөх ба нөхсөн хэсгүүдийг бэхжүүлэх ажлыг мөн гүйцэтгэнэ.Томоохон эвдрэл бүхий 18 хэсэгт замыг 5 м өргөнтэй хуулж нөхөөс хийнэ. Гэр хорооллын шороон замын хотгор гүдгэрийг шороогоор дүүргэж тэгшлэх ажил гүйцэтгэнэ.

5. Техникийн шаардлага

№	Гүйцэтгэх ажлын нэр	хэмжээ	Техникийн шаардлага
1	3.1 км авто замын бага хэмжээний эвдрэлтэй 90 хэсгийн газрыг асфальтаар нөхөх ажил	72 м2	Замын эвдэрсэн хэсгийг хөрөөдөж асфальтаар нөхнө.Суултыг тооцож хонхойж борооны ус тогтохгүй байхаар нөхнө.
2	Шугам сүлжээний ажил хийсний улмаас эвдэрсэн замын хэсгийг хуулж хөрөөдөн технологийн дагуу нөхөөс хийнэ.	15 м2	Цементээр нөхсөн хэсгийг бүрэн хуулж асфальтаар нөхнө. Суултыг тооцож хонхойж борооны ус тогтохгүй байхаар нөхнө.
3	Томоохон хэмжээний эвдрэлтэй замын 17 хэсгийг хөрөөдөн хуулж том хэмжээтэй нөхөөс хийнэ.	49 м2	Эвдэрсэн болон шинээр эвдэрч байгаа хэсгийг бүрэн хуулж хөрөөдөн асфальтаар нөхнө. Суултыг тооцож хонхойж борооны ус тогтохгүй байхаар нөхнө.
4	Асфалтаар нөхсөн бүх хэсгүүдийн заадсыг бэхжүүлэх ажил гүйцэтгэнэ	108 хэсэг 136 м2	Хар тосоор заадсын бэхжүүлэлт хийнэ.
5	6 байшингаас 5 байшин хүртэлх замыг засварлах ажил	700 м	Шугам хоолой тавих үед эвдэрсэн замын эвдрэлийг засна. Грейдэрээр замыг тэгшлэх, индүүдэж нягтруулах ажил гүйцэтгэнэ.
6	5 байшингаас модны зах хүртэлх замыг засварлах ажил	500 м	Тээврийн хэрэгсэл зөрөх боломжтой болгож замыг өргөтгөх,замыг грейдэрээр тэгшлэх ажил гүйцэтгэх ба индүүдэж нягтруулна.
7	Цэцэрлэгийн урд талын гүүр,төв худгийн урд талын гүүр,модот хороолол орох замын гүүр,Бор-Өндөр хороолол орох замын гүүрнүүдийн хоёр талын эвдрэлийг засварлах ажил	400 м	Бүх гүүрнүүдийн хоёр талын тус бүр 100 м замын эвдрэлийг засварлах,хотгор гүдгэрийг дайрга зэрэг урсаж алга болохгүй,суулт өгөхгүй материал ашиглан дүүргэлт хийх тэгшлэх,индүүдэж нягтруулах ажил гүйцэтгэнэ
8	Сумын төвийн Модот хороллын нийт 5 хэсэгт 20 машин шороо буулгаж газрын хотгор гүдгэрийг тэгшлэх ажил хийнэ.	50 машин 360 тонн шороо	Шороон замын эвдрэл хотгор гүдгэрийг шороо асгаж тэгшлэх ажил гүйцэтгэнэ.

Техникийн тодорхойлолт боловсруулсан:
Ажлын хэсэг